

2021

**ГОВЬ-АЛТАЙ АЙМГИЙН
“ГАЗАР ТАРИАЛАН, ЖИМС ЖИМСГЭНЭ”
ТӨСЛИЙН ТЕХНИК, ЭДИЙН ЗАСГИЙН
ҮНДЭСЛЭЛ**

УЛААНБААТАР ХОТ

“ГАЗАР ТАРИАЛАН, ЖИМС ЖИМСГЭНЭ” ХӨТӨЛБӨР



Говь-Алтай аймаг



Говь-Алтай аймгийн хүнс,
хөдөө аж ахуйн газар



“Хөдөө Аж Ахуйн
Инновацийн нэгдэл” ТББ



Хөдөө Аж Ахуйн
Их сургууль

САНААЧЛАГЧ:

Говь-Алтай аймгийн Засаг дарга Очирбатын Амгаланбаатар

ЗАХИАЛАГЧ:

Говь-Алтай аймгийн Засаг даргын Тамгын газар
Аймгийн Хүнс, Хөдөө Аж Ахуйн Газар

ХӨТӨЛБӨРИЙН УДИРДАГЧ:

Төслийн захиалагч талын удирдагч:

Доржийн Батбилэг /Засаг даргын зөвлөх/

Төслийн захиалагч талын багийн гишүүд:

Буудайн Гайтав /Аймгийн ерөнхий агрономич/

Сүхбаатарын Баярмаа /ЗДТГ-ын мэргэжилтэн/

Галбаярын Болд-Эрдэнэ /Аймгийн ГХХБГ-ын ахлах мэргэжилтэн/

ТӨСЛИЙН УДИРДАГЧ:

Базаржавын Мөнхбат

ГҮЙЦЭТГЭГЧ:

Хөдөө Аж Ахуйн Инновацийн нэгдэл” ТББ

Ерөнхий редактор: Ш.Баранчулуун

Редактор: Ж.Чулуунбаатар
Б.Дорж

Хэвлэлийн эх бэлтгэсэн: П.Номинцэцэг

Хавтасны дизайнер: М.Мөнх-Эрдэнэ

Цаасны хэмжээ: 70x100/16

Хэвлэлийн хуудас: 69.5 х.х

Хэвлэлийн “Соёмбо Принтинг” ХХК-д хэвлэв.

ISBN 976-9919-26-288-4

© Зохиогчийн зөвшөөрөлгүй хэвлэн олшруулахыг хориглоно.

ТӨСЛИЙН БАГИЙН ГИШҮҮД

№	Овог нэр	Мэргэжил, зэрэг, цол	Холбоо барих утас, э-майл хаяг
1	Базаржавын Мөнхбат	Механик инженер, Техникийн ухааны доктор (Ph.D), профессор	99081905, munkhbat.b@muls.edu.mn
2	Бэгзийн Дорж	Монгол Улсын Гавьяат Агрономич, ХАА-н шинжлэх ухааны доктор (Sc.D), профессор	99238706, begzdorj@gmail.com
3	Жамсрангийн Чулуунбаатар	Агрономич, ХАА-н ухааны доктор (Ph.D), профессор	Утас: 99717250, ch_suvd@mford.mn
4	Бадамын Нинж	Агрономич, ХАА-н шинжлэх ухааны доктор (Sc.D), профессор	99235153, badamninj@gmail.com
5	Ширчингийн Баранчулуун	Мелиорацийн инженер, гидротехник, ХАА-н ухааны доктор (Ph.D), дэд профессор	99043656, Nomch_br@yahoo.com
6	Жадамбын Очир	Агрономич, ХАА-н ухааны доктор (Ph.D)	99037960, ochir@muls.edu.mn
7	Доошингийн Туул	Хөрс судлаач, агрохимич, ХАА-н ухааны доктор (Ph.D), дэд профессор	88066321, tuuld88@yahoo.com
8	Лхамсүрэнгийн Наранхүү	ХАА-н ахуйн эдийн засагч, эдийн засгийн ухааны доктор (Ph.D), профессор	88551941, l.narankhuu@mnun.edu.mn
9	Төмөрбаатарын Балжинням	Геодезийн инженер, Газар зохион байгуулалт, газрын кадастерийн чиглэлээр ХАА-н ухааны доктор (Ph.D), дэд профессор	99290324, baljinnyam@muls.edu.mn
10	Ходройн Батнаран	Агрономич, ХАА-н ухааны доктор (Ph.D), дэд профессор	98114621, batnarano@yahoo.com
11	Цамбаагийн Батцэрэн	Ургамал зүйч, агрономич, Биологийн ухааны доктор (Ph.D),	99771687, tseegi.b117@gmail.com
12	Амарбатын Бат-Эрдэнэ	Мал зүйч, ХАА-н ухааны доктор, (Ph.D)	99857363, a.baterdene@muls.edu.mn
13	Лувсангийн Лхагвасүрэн	Инженер эдийн засагч, Техникийн ухааны доктор (Ph.D)	99862291, lkhagvasuren@muls.edu.mn
14	Жаргалсайхны Мөнгөн	Механик инженер, Техникийн ухааны доктор (Ph.D)	99027262 mungun@muls.edu.mn
15	Бадрахын Долгормаа	Механик инженер, Техникийн ухааны доктор (Ph.D)	88007746 b.dolgormaa@muls.edu.mn
16	Дархижавын Баянжаргал	Хэрэглээний математикч, эдийн засгийн магистр, тооцоолон бодох, математикийн чиглэлээр доктор (Ph.D), профессор	88019265, bayanjargal@num.edu.mn
17	Эрдэнэчулууны Бат-Эрдэнэ	Инженер агрономич, магистр	80882202, aicmongolia@gmail.com
18	Намсрайн Чинзориг	ХАА-н бизнес, менежмент, Бизнесийн удирдлагын магистр	88058837, chinzorиг.n@muls.edu.mn
19	Г.Мөнхбат	Ойн аж ахуйн инженер, ХАА-н ухааны магистр	94120708 Munkhbat@muls.edu.mn
20	Баранчулууны Амартайван	Усны нөөц, экологич, магистр	89806622, amartaivanbaranchuluun88@gmail.com



ТЕХНИК ЭДИЙН ЗАСГИЙН ҮНДЭСЛЭЛИЙН ЗОРИЛГО, ЗОРИЛТ


Зорилго: Говь-Алтай аймгийн газар тариалангийн үйлдвэрлэлийг тогтвортой хөгжүүлэх нөхцөлийг хангахын тулд одоо болон ирээдүйд авч хэрэгжүүлэх арга хэмжээг оновчтой тодорхойлж түүнийг хэрэгжүүлэхэд шаардагдах хөрөнгө оруулалт, орлого, зардал өгөөж, үр ашгийг төлөвлөхөд оршино.

Зорилтууд:

- 2022 оноос үр тариа, төмс, хүнсний ногоо, жимс жимсгэний тариалах талбайг нэмэгдүүлж олон наст тэжээлийн ургамалын жилд тариалах талбайг 14000 га-д, төмсний тариалах талбайн хэмжээг 100.0 га-д, хүнсний ногооны жилд тариалах талбайн хэмжээг 200-аас доошгүй га-д хүргэх;
- Бүх сумдад халаалтгүй зуны хүлэмж 1-ийг (нийлбэр талбай 1.48 га) барьж байгуулах;
- Тус аймгийн уур амьсгал, ялангуяа хавар зуны улиралд хүчтэй салхитай өдрийн тоо олон байдаг нь жимсний таримлын ургацанд шууд сөрөг нөлөөг үзүүлдэг тул жимс, жимсгэний мод, бутыг салхинаас хамгаалах ойн зурвас байгуулах, жимст цэцэрлэгийн талбайн хэмжээг 2022 онд 1.74 га-гаар нэмэгдүүлэх;
- Суулгац бойжуулалтын талбайг жимст цэцэрлэг эрхэлж ирсэн туршлагатай сумдад бий болгох замаар цаашид цэцэрлэгийн талбайг тэлэх. Үүнд: бэсрэг, давжаа алим, интоорын бойжуулгын газрыг Бигэр сумын Мянгай, Бургас дахь жимст цэцэрлэгийг; үхэр нүд, чавга, бөөрөлзгөнө, алимынхыг Халиун сумын эх цэцэрлэгийг; алим, чацарганы бойжуулгын газрыг Цогт сумын Шугуй, Тэгш дэх эх цэцэрлэгийг тус тус түшиглүүлж байгуулах;
- Алим, интоор, чавганы залгуур ургуулах, залгаадас бэлтгэх, үхэр нүд, бөөрөлзгөнө, чацарганы ногоон мөчрийг мананжуулагч төхөөрөмж бүхий хүлэмжид ургуулж үндэслүүр бэлтгэх чиглэлээр жимсний аж ахуй эрхлэгчдийн дунд сургалт явуулах;
- Бойжуулгын газарт залгагдсан алим, чавга, интоор, ногоон мөчрөөр үндэсжүүлсэн тарьцыг дараа хавар нь сумдад хуваарилан, суулгац үржүүлэх талбайд 1-2 жил ургуулаад бэлэн болсон суулгацыг аж ахуйн нэгж, иргэдэд гэрээ, захиалгаар олгох асуудлыг аймгийн засаг даргын тамгын газар хариуцан гүйцэтгэх;
- Алтай хотын 16.0 мянган хүн амын мах, сүүний жилийн хэрэгцээний 10-30 хувийг хангахын тулд 2022 оноос 692 өсвөр үхэр, 98 саалийн үнээтэй сүүний үхрийн ферм байгуулах;
- Эрчимжсэн мал аж ахуй эрхлэгчид нь эрдэнэшишийг даршинд зориулж 102.6 га-д, тэжээлийн үндэс үрт ногоо 55.1 га-д, хүчит тэжээл (арвай, хошуу будаа, царгас, рапс гм) тус тус тариална;
- Жижиг өрхийн аж ахуйнуудад техникийн үйлчилгээ үзүүлэх зорилго бүхий дундын техникийн үйлчилгээний төв байгуулах;
- 50-250 тонн төмс, хүнсний ногоо хадгалах зоорь барих.

Эрхэм зорилго: *Орон нутгийн нөхцөлд зохицсон технологи, үр, бордоо, ургамлын өвчин хорлогчидтой тэмцэх зохистой арга хэрэглэх, оновчтой ээлжлэн тариалалт нэвтрүүлж газар тариалан, жимс жимсгэний үйлдвэрлэлийг шинжлэх ухааны үндэслэлтэйгээр эрхлэн экологийн цэвэр, органик бүтээгдэхүүн үйлдвэрлэж аймгийнхаа хүн амыг эрүүл аюулгүй хүнсээр хангах.*

Амжилтанд хүрэх хүчин зүйлс:



Баримтлах стратеги: Аймгийн хүнсний бүтээгдэхүүний хэрэгцээг дотоодын үйлдвэрлэлээр хангах эрэлт их байгаа боломжийг ашиглан үйлдвэрлэлийг шинжлэх ухааны үндэслэлтэйгээр байгал цаг уурын хүчин зүйлээс хамаарал багатайгаар эрхлэж, орон нутгийн зах зээлийн хэрэгцээг аль болох хямд, эрүүл бүтээгдэхүүнээр хангах стратеги баримтлана.


Техник, эдийн засгийн үндэслэлийн үр дүн

Уг техник, эдийн засгийн үндэслэлийг хэрэгжүүлсэний үр дүнг дараах байдлаар тодорхойлж байна. Үүнд:

- Ажлын байрыг шинээр бий болгоно.
- Иргэдийн орлогын эх үүсвэрийг нэмэгдүүлнэ.
- Гадаад худалдааны алдагдлыг бууруулж, импортыг орлох бүтээгдэхүүний үйлдвэрлэлийг нэмэгдүүлнэ.
- Үр тариа, тэжээлийн ургамал, төмс, хүнсний ногооны үйлдвэрлэлийг тогтвортой нэмэгдүүлж, хүн амын хүнсний хэрэглээг экологийн цэвэр хүнсний бүтээгдэхүүнээр хангахад хувь нэмэр оруулна.
- Үйлдвэрлэгчдийг технологийн шаардлагад нийцсэн жимсний модны суулгац, тарьц, үрээр хангана.
- Улс орны болон бүс нутгийн хэмжээнд загвар болохуйц хүлэмжийн аж ахуй жимс, жимсгэнийн аж ахуйн суурийг тавина.

Бүтээгдэхүүн үйлчилгээний нэр төрөл, хэмжээ: Арвайн гурил, ил болон хамгаалалттай хөрсний ногоо, шууд болон боловсруулж хэрэглэх зориулалттай жимс, жимсгэнэ, чанамал, жимсний шүүс, тарьц, суулгац, тэжээлийн ургамал

Бүтээгдэхүүн үйлчилгээний онцлог:



Хэрэгжүүлэх үйл ажиллагаа:

1. Үр тариа, тэжээлийн ургамал, ил ба хүлэмжийн ногоо тарьж ургуулах бэлтгэл ажлыг хангаж тариалах, ургуулах, хураах, борлуулах;
2. Жимс, жимсгэний тарьц, суулгац ургуулах сургалт зохион байгуулж тарьц, суулгац бэлтгэж борлуулах;
3. Жимсний мод, бутыг арчилж тордон ургуулах;
4. Бэлэн болсон төмс, хүнсний ногоо хадгалах зоорь барих;
5. Жижиг өрхийн үйлдвэрлэгчдэд үйлчлэх техникийн дундын төв барьж байгуулах;
6. Говь-Алтай аймгийн сүү, мах, өндөгний хэрэгцээг хангах сүү, махны үхэр, гахай шувууны аж ахуй байгуулах.